

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2024/2

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.II	2023.II	2024.I	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 4-р улирал	их наяд ₮, оны үнээр	68.8	52.8	46.5	-	-	-	7.0% ▲
Инфляц	хувь	7.0	12.2	7.6	0.7% ▲	-	1.5% ▲	-5.2 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	3.9% 2023 оны У4	5.3% 2022 оны У4	3.9% 2023 оны У4	-	-1.3% ▼ нэгж хувиар	-	-1.4% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1342	23	676	667 ▲	-	-	1320 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3391.80	3508.06	3407.37	-15.57 ▼	-	-	-116.26 ▼
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	1050.5	1045.3	388.9	-	-	-	5.2 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	10.6	8.0	6.6	-	-	-	2.6 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	253.6	218.5	124.1	-	-	-	20% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	13%	13%	0%	-	0%	0%
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.97	3.39	4.84	2.5% ▲	-	-	46.4% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	7.29%	9.93%	7.38%	-0.1 нэгж хувиар ▼	-	-	-2.64 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Улсын хэмжээнд 2-р сарын 26-ны байдлаар 2,136,563 толгой мал хорогдоод байна.	Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хорогдсон малын тоо 85.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Тодруулбал Сүхбаатар, Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Дундговь аймгуудад малын хорогдол хамгийн өндөр байна гэж ОБЕГазараас мэдээллэв.
Төгрөгийн ханш чангарсаар	Төгрөгийн ханш сүүлийн 5 сар дараалан чангарсаар байна. Энэ нь гадаад худалдаа болон үрсгал тэнцлүүд ашигтай гарсан мөн нүүрсний экспорт сайн хийгдэж буйтай холбоотой.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Монголбанк бодлогын хүүгээ бууруулав.	3/15/2024	Жилийн инфляц 2024 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувь, Улаанбаатар хотод 7.2 хувьд хүрч буурлаа. Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлого, худалдааны түнш орнуудын буурч буй инфляц, чангарч буй төгрөгийн гадаад валюттай харьцах ханш зэрэг нь нийт инфляцын бууралтад гол нөлөө үзүүлэв. Цаашид инфляц алгуур буурч, төв банкны зорилтын дээд интервалын орчимд байх төлөвтэй байна.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График


Нөлөөлөл

Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 2 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.0 хувь, өмнөх оны эцсээс 1.5 хувь, өмнөх сараас 0.7 хувиар өссөн байна. 2024 оны 2 дугаар сард Хангайн бүсэд барааны бүлгийн үнэ 8.1 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 8.3 хувь, Төвийн бүсэд хүнсний бүлгийн үнэ 11.3 хувь, Улаанбаатар хотод хүнсний бус бүлгийн үнэ 6.1 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

Валютын ханш




Америк долларын ханш 2024 оны 2 дүгээр сард 3391.80 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 116.26 төгрөгөөр, өмнөх сараас 15.57 төгрөгөөр тус тус суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 2.5%, өнгөрсөн жилийн мөн үеэс 46.4%-иар тус тус өсөж, 4.97 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2024 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 5.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.4 (78.4%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 5.1 их наяд төгрөгт хүрч, 2.3 (83.1%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2024 оны эхний 2 сард 3.8 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2024 оны эхний 2 сард нийт 121 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.8 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 2.2 тэрбум ам.доллар, импорт 1.6 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 644.4 сая ам.долларын ашигтай гарсан байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 388.4 (11.3%) сая ам.доллар, импорт 397.2 (33.1%) сая ам.доллаароор тус тус өсөж, экспорт 8.9 (0.4%) сая ам.доллар, тэнцэл 406.1 (38.7%) сая ам.доллаароор тус тус буурсан байна.

Дэлхийн эдийн засагт

- 2024 онд Монгол Улсын эдийн засаг 5.9 хувь өснө. Эх үүсвэр: Азийн хөгжлийн банк
- Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийг 6.2% өснө гэж таамаглажээ.
- БНХАУ-ын эдийн засаг 2023 онд 5.2% өсөв.

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 2-р сар 2024 он, Үндэсний статистикийн хороо](#)
2. [Статистикийн бюллетень, 2-р сар 2024 он, Монголбанк](#)
3. www.1212.mn, www.monqolbank.mn